



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 1/549

Алтай хот


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, 4.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 41 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Газар тариалан, жимс жимсгэнэ” төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас гэрээгээр нийлүүлэгдэж буй хөдөө аж ахуйн зориулалттай трактор, техник тоног төхөөрөмжийн иж бүрдлийг орон нутаг руу тээвэрлэхэд шаардагдах 19,900,000 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат) даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР